



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/228

Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:


1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг нэгдүгээр, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллах, иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулахыг Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Амаржих газар, Түргэн тусламжийн төв, Сувиллын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журам"-ыг баталсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 470 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЛАМБАА

080831

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 06 сарын 15 өдрийн
4/228 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

№	“Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”		
1	Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		
2	Үйлчлүүлэгч /иргэн, аж ахуй нэгж, байгууллага/-ийн хүсэлтээр үзүүлэх тусламж үйлчилгээ		
3	Донтолт, архидалт, мансуурлаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, эмчилгээ		
4	Сайн дурын дархлаажуулалт		
4.1	Гепатит В вирусийн эсрэг вакцин		
4.2	Гепатит А вирусийн эсрэг вакцин		
4.3	Балнадын эсрэг вакцин		
4.4	Сахуу татрангийн эсрэг вакцин		
4.5	Менингитийн эсрэг вакцин		
4.6	Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг гуравт вакцин		
4.7	Шар чичрэгийн эсрэг вакцин		
4.8	Томуугийн эсрэг вакцин		
4.9	Хүний хэвийн иммуноглобулин		
4.10	Стафиллакоккийн эсрэг иммуноглобулин		
4.11	Стафиллакоккийн эсрэг анатоксин		
4.12	Тарваган тахлын эсрэг вакцин		
4.13	Боомын эсрэг вакцин		
4.14	Боомын иммуноглобулин		
4.15	Галзуугийн иммуноглобулин		
4.16	Галзуугийн эсрэгвакцин		
4.17	Хачигт энцефалитын эсрэг вакцин		
4.18	Хачигт энцефалитын иммуноглобулин		
4.19	Харшлын аллерген эмчилгээ		
5	Эрүүл мэндийн даатгалгүй, өөрийн хүсэлтээр шатлал алгассан, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ авах зардлын төлбөр нь тухайн улирлын болон жилийн дээд хязгаараас хэтэрсэн үйлчлүүлэгчдэд доорх эмнэлгийн тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.		
5.1	Насанд хүрэгчдийн шүдний зарим оношилгоо, эмчилгээ		
5.1.1	Цоорол	Өнгөц	
5.1.2		Дунд	
5.1.3		Гүн	
5.1.4	Зөөлцийн үрэвсэл	1 сурвалжтай	
5.1.5		2 сурвалжтай	
5.1.6		3 сурвалжтай	
5.1.7	Холбоосын үрэвсэл	1 сурвалжтай	
5.1.8		2 сурвалжтай	
5.1.9		3 сурвалжтай	
5.1.10	Байнгын ломбо тавих	Цемент	
5.1.11		Глассиономер	
5.1.12		Өөрөө хатуурагч хуванцар	
5.1.13		Гэрлээр хатуурагч хуванцар	
5.1.14		Хуучин ломбо авах	
5.1.15		Бүтэн шүдний хөндийг нээх	
5.1.16		Эмчилгээний жийргэвч	
5.1.17	Түр ломбо	Тусгаарлах жийргэвч	
5.1.18		Ломбо	
5.1.19		Мэдээ алдуулах	
5.1.20	Сувгийн эмчилгээ	Мышьяк тавих /Хүнцэл/	
5.1.21		Шүдний хөндийг нээх	
5.1.22		Зөөлц авах (1 суваг)	
5.1.23		Суваг өргөсгөх, цэвэрлэх (1 суваг)	
5.1.24		Шүдний сувгийн эм солих (давтан)	
5.1.25		Шүдний суваг помбодох (1 суваг)	
5.1.26		Шүдний хуучин ломбо авах (1 суваг)	
5.1.27		Шүдний чулуу цэвэрлэх (1 шүд)	
5.1.28		Шүдний тойрон эдийн эмчилгээ	Буйланд эм тавих, шавхлага хийх (1 удаа)
5.1.29			Салстын эмчилгээ (1 удаа)

5.1.30		Шүдний хатуу эдэд лак, гель түрхэх
5.1.31	Амны хөндийн үйлчилгээ	Шүд цайруулах эмчилгээ /бүрэн/
5.1.32		Шүдний сувгаар цайруулах эмчилгээ (1 шүд)
5.1.33		Голонцортой шүд хийх
5.1.34		Шүдний паалан
5.1.35		Силант
5.1.36		Бүх шүдний өнгөлгөө
5.1.37		Шүдний буйлны эмгэг хөндийг хусаж цэвэрлэх /SRP/ (1 шүд)
5.1.38		Хүүхдийн сүүн шүдний металл түр бүрээс (1 шүд)
5.1.39	Мэс ажилбар	Байнгын шүд авах
5.1.40		Сүүн шүд авах
5.1.41		Буруу байрлалтай, хүндрэлтэй шүд авч, оёдол тавих
5.1.42		Саатсан агт араа далд ургалттай
5.1.43		Хөндлөн байрлалтай
5.1.44		Хэлний хөвч уртасгах
5.1.45		Салстын уйланхай авах
5.1.46		Шүдний гаралтай ясны хальсны идээт үрэвсэл нээх
5.1.47		Буглаа нэвчдээс, хажиг мундас нээх
5.1.48		Эрүүний ясны хугаралд чиг тавих
5.1.49		Шүд авсан ором цэвэрлэх
5.1.50		Гэмтлийн гаралтай шарханд оёдол тавих /шархнаас хамаарч/
5.1.51		Мэдээ алдуулалт
5.1.52		Шүд авсаны дараах цус тогтоолт
5.1.53	Хагас болон бүрэн мултарсан шүдэнд чиг тавих	
5.1.54	Буйл тайрах	
5.1.55	Алькоголизаци ба хориг	
5.1.56	Түүшин засах	
5.1.57	Тулгуур эдийн хагалгаа (1 шүд)	
5.1.58	Шүдний имплант хийх (1 шүд)	
5.1.59	Шүдний суурийн оройн уйланхай авах	
5.1.60	Брекет системийн эмчилгээ	
5.1.61	Гингвоэктомия, Гингвотомия /буйл тайрах, томорсон буйл авах/	
5.1.62	Сиалографи хийх /шүлсний булчирхайн тодотгогч бодис шахаж зураг авах/	
5.1.63	Уян тагнаатай авагддаг шүдэлбэр	1 шүдтэй шүдэлбэр
5.1.64		2 шүдтэй шүдэлбэр
5.1.65		3 шүдтэй шүдэлбэр
5.1.66		4 шүдтэй шүдэлбэр
5.1.67		5 шүдтэй шүдэлбэр
5.1.68		6 шүдтэй шүдэлбэр
5.1.69		7 шүдтэй шүдэлбэр
5.1.70		8 шүдтэй шүдэлбэр
5.1.71		9 шүдтэй шүдэлбэр
5.1.72		10 шүдтэй шүдэлбэр
5.1.73		11 шүдтэй шүдэлбэр
5.1.74		12 шүдтэй шүдэлбэр
5.1.75		13 шүдтэй шүдэлбэр
5.1.76		14 шүдтэй шүдэлбэр
5.1.77	Цутгамал суурьтай авагддаг шүдэлбэр	Дээд
5.1.78		Доод
5.1.79	Авагддаггүй шүдэлбэр	Шаазан бүрээс
5.1.80		Цутгамал ган бүрээс
5.1.81		Алт монетон бүрээс /үнэт металлыг хувь хүн гаргана/
5.1.82		Хуванцар бүрээс
5.1.83	Шахмал хуванцар суурьтай авагддаг шүдэлбэр	1 шүдтэй шүдэлбэр
5.1.84		2 шүдтэй шүдэлбэр
5.1.85		3 шүдтэй шүдэлбэр
5.1.86		4 шүдтэй шүдэлбэр
5.1.87		5 шүдтэй шүдэлбэр
5.1.88		6 шүдтэй шүдэлбэр
5.1.89		7 шүдтэй шүдэлбэр
5.1.90		8 шүдтэй шүдэлбэр
5.1.91		9 шүдтэй шүдэлбэр
5.1.92		10 шүдтэй шүдэлбэр
5.1.93		11 шүдтэй шүдэлбэр

5.1.94		12 шүдтэй шүдэлбэр
5.1.95		13 шүдтэй шүдэлбэр
5.1.96		14 шүдтэй шүдэлбэр
5.1.97		Бүрэн шүдтэй шүдэлбэр
5.1.98		Тэлэгч эрэг
5.1.99		Тэлэгч пүрш
5.1.100		Хуруун пүрш
5.1.101		Түлхэгч пүрш
5.1.102		Уруулын нум
5.1.103		Адамсын дэгээ
5.1.104		Нүд хэлбэрийн дэгээ
5.1.105		Цэцгэн дэгээ
5.1.106		Суман дэгээ
5.1.107		Зэллэсэн дэгээ
5.1.108		Суурь ялтас
5.1.109		Хазалтын налуу
5.1.110	Согог, гажиг заслын авдаг зэмсэг	Хазалтын хавтгай
5.1.111		Зөөлөн хэв
5.1.112		Туслах материал
5.1.113		Толгойн боолт татлага
5.1.114		Нүүрний маск татлага
5.1.115		Ховхорсон брекет
5.1.116		Нэмэлт хэсэгтэй нум
5.1.117		Уруулын даравч
5.1.118		Хацрын хөндийрүүлэгч
5.1.119		Чулуун загвар
5.1.120		MRC /гажиг заслын зэмсэг/
5.1.121		Ялтсан зэмсэг
5.1.122		Микро имплант
5.1.123		Онош тогтоох
5.1.124		Загвар
5.1.125		Хэв
5.1.126		Брекет /ган/
5.1.127		Банд
5.1.128	Согог, гажиг заслын авагддаггүй зэмсэг	Нум /1 ширхэг/
5.1.129		Холбогч резин, татлагын резин /1 ширхэг/
5.1.130		Зай гаргагч резин, металл зай гаргагч /1 ширхэг/
5.1.131		Брекет наах /1 ширхэг/
5.1.132		Брекет систем /металл/
5.1.133		Брекет систем /шаазан/
5.1.134		Хуванцар тагнай
5.1.135		Хуванцар буйл
5.1.136		Хуванцар шүд
5.1.137		Зөөлөн хэв
5.1.138	Бусад	Туслах материал
5.1.139		Тусгай халбага
5.1.140		1 шүд нэмэх
5.1.141		Засвар шүдэлбэр
5.1.142		Нэмэлт хуванцар суурь хийх /пербазировка/
6	Иргэн санаатайгаар амь насаа егүүтгэхээр оролдсон тохиолдлын эмнэлгийн тусламж үйлчилгээ	
7	Даатгал болон төр хариуцдаггүй, шинээр нэвтэрч буй технологийн шинэчлэлт хийгдсэн тусламж үйлчилгээ	
8	Гоо заслын болон нөхөн сэргээх тусламж үйлчилгээ	
8.1	Гоо заслын тусламж үйлчилгээ	
8.1.1	Сэтэрхий чих оёх /2 тал/	
8.1.2	Чихний дэлдэн засах	
8.1.3	Чих цоолох	
8.1.4	Хамрын хуучин хугарал засах	
8.1.5	Хамар өндөрлөх	
8.1.6	Хамар, чихнээс гадны биет авах	
8.1.7	Нүдний мах хусах	
8.1.8	Наснаас хамааралтай блефаро-халазис	
8.1.9	Доод зовхины урвалт засах	
8.1.10	Нүдэнд давхраа хийх	
8.1.11	Хүүхдэд гоо сайхны зориулалтаар	Нэг тал
8.1.12	гажиг заслын авагддаг зэмсэг хийх	Хоёр тал

8.1.13	Хүүхдэд гоо сайхны зориулалтаар гажиг заслын авагддаггүй зэмсэг хийх
8.1.14	Уруулын сэтэрхий оёх
8.1.15	Уруулын хөвч гүнзгийрүүлэх
8.1.16	Сорви цэгцлэх /1см/
8.1.17	Сорви засах
8.1.18	Сорви зөөлрүүлэх тариа хийх
8.1.19	Үрэвсэлгүй хар, цагаан батга цэвэрлэх
8.1.20	Нүүрэнд эрүүл ахуйн иллэг хийх
8.1.21	Арьсны хоргүй хавдар, үү, мэнгийг цахилгаанаар түлж авах (Электрокоагуляци эмчилгээ) /жижиг хэмжээтэй/
8.1.22	Арьсны хоргүй хавдар, үү, мэнгийг цахилгаанаар түлж авах (Электрокоагуляци эмчилгээ) /том хэмжээтэй/
8.1.23	Арьсны хоргүй хавдар, үү, мэнгэ авах (CO2 лазер) /том хэмжээтэй 1 ш/
8.1.24	Арьсны хоргүй хавдар авах (CO2 лазер) /их хэмжээний/
8.1.25	Хөлдөөх эмчилгээгээр үү эмчлэх /1 ш/
8.1.26	Лазер эмчилгээ /нүүрний нөсөөт толбо, шивээс арилгах-Lentigo/
8.1.27	Батганы сорвины лазер
8.1.28	Өргөссөн судасны лазер эмчилгээ /бага хэмжээтэй/
8.1.29	Өргөссөн судасны лазер эмчилгээ /дунд хэмжээтэй/
8.1.30	Өргөссөн судасны лазер эмчилгээ /их хэмжээтэй/
8.1.31	RF (Арьс залуужуулах, чангалах массажны аппарат) 1 удаа
8.1.32	Гормоны тарилга эмчилгээ (Голомтот үс халцрал, зангилаат маажуур, келойд сорви) 1 удаа
8.1.33	Ялтас эсээр баяжуулсан сийвэн тарих эмчилгээ /нэг удаа/ (PRP)
8.1.34	Сорил гадаад 1 төрөл
8.1.35	Сорил монгол 1 төрөл
8.1.36	Хумс аппаратаар эмчлэх /1 хумс/
8.1.37	Сийвэн эмчилгээ 1 удаа (Аутоплазм эмчилгээ)
8.1.38	Цус шүүх эмчилгээ хагас автомат 1 удаа (Плазмферез эмчилгээ)
8.1.39	Цус шүүх эмчилгээ хагас автомат 1 удаа бүрэн автомат (Плазмферез аппаратаар)
8.1.40	Халдварт нялаахайг гараар түүх 1 ш
8.1.41	Хүзүүний булчирхайн тунгалагийн биопси
8.1.42	Эрүүг шилбэний ясаар орлуулах
8.1.43	Хүзүүний гилжгий засах
8.2	Нөхөн сэргээх мэс заслын тусламж, үйлчилгээ
8.2.1	Хярзан нөхөн сэргээх мэс засал /ТОТ хэрэглээгүй/
8.2.2	Хярзан нөхөн сэргээх мэс засал /ТОТ хэрэглэсэн/
8.2.3	Шаамий засах эрүүний ясны мэс засал
9	Эмчийн үзлэг
9.1	Эмчийн үзлэг
9.2	Ахлах, тэргүүлэх болон клиникийн профессор эмчийн үзлэг
9.3	Гавьяат эмч, АУ-ын доктор, зөвлөх эмчийн үзлэг
10	Сувилахуйн тусламж, үйлчилгээ
10.1	Ходоод угаах
10.2	Цөс угаах
10.3	Клизм тавих
10.4	Дуслаар тариа хийх
10.5	Судсанд тариа хийх
10.6	Булчинд тариа хийх
10.7	Арьсан дор тариа хийх
10.8	Цэвэрлэх бургуй
10.9	Эмчилгээний бургуй
10.10	УФОК цус шарах
10.11	Судсанд гуурс тавих
10.12	Эгэмний доод венд гуурс тавих
10.13	Давсаг угаах
10.14	Шээс авах
10.15	Төмсөгний ус авах
10.16	Үтрээнд цацлага хийх
10.17	Боолт хийх 1 удаагийн /цэвэр, бохир/
11	Амбулатороор хийгдэх эмчилгээ
11.1	Хатаах тариа хийх
11.2	Шамбарам резин цагирагаар боох
11.3	Хэт улаан туяагаар шамбарам шарах
11.4	Салстад тариа хийх
11.5	Парабульбар смесь тарих /холимог/
11.6	Ретробульбар тариа хийх
11.7	Эвэрлэг, салстаас гадны биет авах
11.8	Нулимсны зам сэтгүүрдэж угаах

11.9	Өвдөг нээх	
11.10	Халазион нээх	
11.11	Зовхинд массаж хийх	
11.12	Торлогийн лазер	
11.13	Хатиг, арьсан дорхи буглаа нээх	
11.14	Шарханд анхдагч, хоёрдогч цэгцлэлт хийх	
11.15	Сорви авах /1см/	
11.16	Гигром, атром авах	
11.17	Арьсан доорхи, хумсан доорхи ясанд орсон хэлбэрийн үед нээлт хийх	
11.18	Хэвлий, цээжний хөндийд пункци хийх	
11.19	Асцитын үед хэвлийн хөндийн шингэн авах	
11.20	Өөхөн хавдар авах 5 см хүртэл	
11.21	Өөхөн хавдах авах 5 см дээш	
11.22	Хурууны 1-2 үе тайрах	
11.23	Идээлсэн атром авах	
11.24	Суганы булчирхай авах	
11.25	Спираль тавих /нарколог эмчийн заалттай тохиолдолд/	
11.26	Анофтальмын үед хийх имплант	
11.27	Птозын хагалгаанд хэрэглэгдэх имплант	
11.28	Нулимсны суваг сэргээх имплант	
11.29		Толгойны өвдөлт намдаах мигрений эмийн эмчилгээ
11.30		Толгойны өвдөлт намдаах мигрений ботулизм токсин эмчилгээ
11.31		Тархины цус харвалтын дараах өвдөлт намдаах эмчилгээ
11.32		Гурвалсан мэдрэлийн өвдөлт эмийн эмчилгээ
11.33		Гурвалсан мэдрэлийн өвдөлт эмийн эмчилгээний хориг
11.34		Хүзүү орчмын нийлмэл өвдөлт намдаах "Stellate ganglion" хориг
11.35		Хүзүүний булчингийн өвдөлт намдаах "Trigger point injection"
11.36		Гар дагасан дал мөрний өвдөлт "Suprascapular" хориг
11.37		Хүзүү сээрний орчмын radicular өвдөлт "Nerve root" хориг
11.38		Хүзүүний epidural steroid injection
11.39		Нурууны өвдөлт рентген хяналтан дор Nerve root хориг
11.40		Сүүжний ясны өвдөлт sacroiliac joint хориг
11.41		Facet block-ууд /сээр, нуруу, хүзүү/
11.42		Өвдөгний өвдөлт
11.43		Шагайны өвдөлт
11.44		Хэвлийн өвдөлт
11.45		Ташаа цавины өвдөлт
11.46		Ууцны хориг
11.47		Эпидурал хориг
11.48		Шодойн хориг
11.49		Хавирга хоорондын хориг
11.50		ТАФ хориг
11.51		Ганглион хориг
11.52		Могойн яр бүх төрлийн өвдөлт намдаах
12	Стрессийн шалтгаант мэдрэлийн ядаргаа, нойргүйдэл зэрэг эмгэгийн оношилгоо, эмчилгээ	
13	Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үйлчилгээ	
13.1	Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө /1 удаа 60 мин/	
13.2	Ганцаарчилсан сэтгэл засал эмчилгээ /1 удаа 90 мин хүртэл/	
13.3	Гэр бүлийн сэтгэл засал /1 удаа 90 мин/	
13.4	Хосын сэтгэл засал /1 удаа 90 мин/	
14	Сэтгэл зүйн оношилгоо	
14.1	Танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа тодорхойлох сорил	
14.2	Оюуны түвшин (IQ) тогтоох сорил	
14.3	Бие хүн тодорхойлох сорил	
14.4	Эмнэлзүйн сэтгэл судлалын шинжилгээ	
14.5	Өөрийгөө удирдах эмчилгээний дасгал /1удаа/	
14.6	Секспатологич эмчийн үзлэг	
14.7	Түрүү булчирхайн массаж /1 удаа/	
14.8	Оюуны ачаалал, ойлгох чадварыг тодорхойлох сорил	
14.9	Сэтгэцийн үйл ажиллагааны багц сорил	
14.10	Хүүхдийн авьяас, мэргэжил тодорхойлох сорил	
15	Шүүх, сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ	
15.1	Шүүх, сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргах /анх удаа/	


15.2	Шүүх, сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргах /давтан/	
15.3	Полиграфийн шинжилгээ, дүгнэлт	
16	Эрүүл мэндийн дүгнэлт гаргах	
16.1	Эрүүл мэндийн дүгнэлт гаргах /оношилгоо, шинжилгээ ороогүй/	Жолооны үнэмлэх авах
16.2		Гэр бүл болох, ажил сургуульд орох
16.3		Гадаад явах
17	Жирэмсний эрт үеийн үр хөндөлт /12 долоо хоног хүртэлх/ /эмнэлгийн заалтаар хийх үр хөндөлт хамаарахгүй/	
17.1	Эмийн аргаар үр хөндөх	
17.2	Гар соруурын аргаар ажилбар хийх /унтуулгагүй/	
17.3	Гар соруурын аргаар ажилбар хийх /унтуулгатай/	
18	Үргүйдлийн тусламж үйлчилгээ	
18.1	Оношилгоо	Үрийн шингэний ерөнхий шинжилгээ
18.2		Үрийн шингэний дэлгэрэнгүй шинжилгээ
18.3		Эр үрийн шингэний шинжилгээ
18.4		Чанд авиан шинжилгээ (анх удаа)
18.5		Чанд авиан шинжилгээ (давтан)
18.6		Чанд авиан шинжилгээ (төмсөг, төмсөгний дайвар, түрүү булчирхай, үрийн цулцан)
18.7	Эмчилгээ	Үр цацах эмчилгээ (өндгөвч сэдээхгүй үед)
18.8		Үр цацах эмчилгээ (кломифен цитратаар өндгөвч сэдээх үед)
18.9		Зохиомлоор үр тогтоох эмчилгээ (Шар биеийн дааврийг саатуулах өндгөвч сэдээх бол)
18.10		Зохиомлоор үр тогтоох эмчилгээ (Шар биеийн дааврийг дэмжих өндгөвч сэдээх бол)
18.11		Зохиомлоор үр тогтоох эмчилгээ (Урт хугацаанд өндгөвч сэдээх бол)
18.12		Өндгөн эсэд эр бэлгийн эс тарьж үр тогтоох
18.13	Бэлгийн эс, төмсөг, өндгөвчний эд хөлдөөх	
18.14	Үрийн шингэнд эр эс байхгүй үед төмсгөнд оношилгоо эмчилгээний зорилгоор хатгалт хийх (PESA)	
18.15	Үрийн шингэнд эр эс байхгүй үед төмсгөнд оношилгоо эмчилгээний зорилгоор төмсөгний эдийг авах (TESE)	
19	Зайн оношилгоо	
19.1	Зайн оношилгоо /нэг удаагийн/	Зайн зүрхний бичлэг
19.2		Зайн тархины бичлэг
19.3		Зайн спирограмм
19.4		Зайн сахар оношилгоо
19.5		Зайн хэт авиан оношилгоо
19.6		Зайн рентген
19.7	Зайн зөвлөгөө /нэг удаагийн/	
20	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс бусад эрүүл мэндийн байгууллагаас гэрээр үзүүлэх	
20.1	Гэрийн асаргаа сувилгаа	Бүх биеийн угаалга
20.2		Толгой угаалга
20.3		Хэсэгчилсэн угаалга
20.4		Амны хөндийн арчилгаа
20.5		Цагаан хэрэглэл солих
20.6		Нуралт, холголт, цооролтоос урьдчилан сэргийлэх сувилахуйн тусламж
20.7		Хэвтрийн өвчтөнийг хооллох /гуурсаар/
20.8		Өвчтөн амирлах үед сувилгаа хийх, гэр бүлийн гишүүдийн сэтгэл санааг дэмжих
20.9		Хүнд өвчтөний асаргаа сувилгааны талаар гэр бүлийнхэнд сургалт явуулах /1цаг/
20.10		Колостомийн сувилгаа хийж өгөх /Бүдүүн гэдсэнд гуурс тавиж цэвэрлэх/
20.11		Трахеостомийн сувилгаа /Цагаан мөгөөрсөн хоолойн гуурс цэвэрлэх, солих/
20.12		Хагас суугаа байрлалд оруулж өгөх
20.13		Дасгал хөдөлгөөн заах
20.14		Хүнд болон хэвтрийн өвчтөнийг гэрт асарч сахихад:
20.15		1 цагт
20.16		8 цагт
20.17		24 цагт
20.18		Хүнд болон хэвтрийн өвчтөнийг эмнэлэгт асарч сахихад:
20.19		1 цагт

20.20		8 цагт
20.21		24 цагт
20.22		Химийн тариа хийх /2 цаг/
20.23		Химийн тариа хийх /24 цагаар/
20.24		Ходоод хаймсуурдах, угаах /эмчтэй хамт/
21	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэггүй эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх зарим оношилгоо, шинжилгээ, тусламж үйлчилгээ	
22	Иммуногематологийн шинжилгээ	
22.1	Эргэлзээтэй цусны бүлэг тодорхойлж баталгаажуулах	
22.2	Цусны ABO, резус бүлэг тодорхойлох	
22.3	Цусны резус бүлэг баталгаажуулах	
22.4	Хувийн тохироо тодорхойлох	
22.5	anti-A титр	
22.6	Улаан эсийн эсрэг бие илрүүлэлт	
22.7	Улаан эсийн эсрэг бие ялган дүйлт	
22.8	Кумбсын шууд болон шууд бус урвалын шинжилгээ /тус тусдаа/	
23	Эд, эсийн шинжилгээ	
23.1	Эд эсийн шинжилгээ авах задлах эсийн наац /зүүгээр, түрхэцийн/, биопси /эд/ авах, нээлттэй, зүүгээр/	
23.2	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	
23.3	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ (FNA)	
23.4	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд/	
23.5	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /ясны эд/	
23.6	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /мэс ажилбараар авсан эд/	
23.7	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторит шинжлэх /эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй/	
23.8	Ясны хэмийн эдийн шинжилгээ авах, лабораторит шинжлэх /эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй/	
23.9	Хувийн эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр хийх эмгэг судлалын задлан шинжилгээ	
23.10	Иммуногистохимийн шинжилгээ /маркерийн тооноос шалтгаална/	
23.11	Арьсны эдийн шинжилгээ авах, шууд дархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх, онош дүгнэлт өгөх	
23.12	Шууд бус дархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх, онош дүгнэлт өгөх	
23.13	Дерматологийн мозайк-арьсны аутоиммун цэврүүт өвчнүүдийг ялган оношлох бүрдэл	
23.14	Арьсны хавдар болон бусад өвчнүүдийн ялган оношлох иммуногистохимийн будгийн арга (үзүүлэлт тус бүр)	
23.15	Арьсны бүтцийн уургуудийг эсрэг ауто эсрэг бие илрүүлэх шинжилгээ	
23.16	Хачиг илрүүлэх шинжилгээ (Демодекс)	
23.17	Мөөгөнцөрийн үүсгэгчийг микроскопоор харах	
23.18	Мөөгөнцөрийн өсгөврийн тэжээлт орчинд ургуулах	
23.19	Кандид ургалт	
24	Орчин хүнстэй холбогдох шинжилгээ	
24.1	Ундны усанд хийх шинжилгээ	Ундны усанд физик химийн үзүүлэлтүүд үзэх
24.2		Ундны усанд Катион тодорхойлох
24.3		Ундны усанд Анион тодорхойлох
24.4		Мэдэрхүйн шинжилгээ хийх
24.5	Бохир усанд хийгдэх шинжилгээ	Бохир усанд физик химийн үзүүлэлтүүд үзэх
24.6		Бохир усанд Катион тодорхойлох
24.7		Бохир усанд Анион тодорхойлох
24.8		Бохир усанд Мэдэрхүйн шинжилгээ хийх
24.9	Орчны агаарын шинжилгээ	Орчны агаарт хүхэрлэг хий (SO ₂)
24.10		Орчны агаарт азотын давхар исэл (NO ₂)
24.11		Орчны агаарт нүүрстөрөгчийн дутуу исэл (SO ₂)
24.12		Орчны агаарт тоосны хэмжээ (PM-2.5)
24.13	Микробиологийн лабораторит хийх	Нянгийн нийт тоо тодорхойлох
24.14		E.coli тоо тодорхойлох
24.15		Энтерококк тодорхойлох
24.16		Цус задлагч нян тодорхойлох
24.17		Хөгц мөөгөнцөр тодорхойлох
24.18		Эмгэг төрөгч нян тодорхойлох
24.19		Агааргүйтэн бактер тодорхойлох
24.20		Протеус тодорхойлох
24.21		Арчдас авах
24.22		Стафилококк тодорхойлох

24.23	Шинжилгээ	V810 Ундны уснаас хүхэрт устөрөгч илрүүлэх оношлуур (шилтэй)
24.24		V810 Ундны уснаас хүхэрт устөрөгч илрүүлэх оношлуур (шилгүй)
24.25		V111 Ундны усны колиформ нянг илрүүлэх оношлуур (шилтэй)
24.26		V111 Ундны усны колиформ нянг илрүүлэх оношлуур (шилгүй)
24.27		SI Арчдасны шинжилгээний оношлуур (шилтэй)
24.28		SI Арчдасны шинжилгээний оношлуур (шилгүй)
25	Шим тэжээлийн лабораторт хийх шинжилгээ	
25.1	Хоолны дээж	Хоолны дээжний ерөнхий шинжилгээ
25.2		C аминдэм тодорхойлох
25.3		Төмөр тодорхойлох
25.4		Кальци тодорхойлох
25.5		Магни тодорхойлох
25.6		Фосфор тодорхойлох
25.7		Ерөнхий хүчиллэг тодорхойлох
25.8		Хоолны давс тодорхойлох
25.9	Гурил	Гуриланд чийг тодорхойлох
25.10		Ерөнхий эрдэс тодорхойлох
25.11		Өөх тос тодорхойлох
25.12		Нүүрс ус тодорхойлох
25.13		Уургийн бодистодорхойлох
25.14		Цавуулаг тодорхойлох
25.15		Цардуул тодорхойлох
25.16		Хүчиллэг тодорхойлох
25.17	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Исгэлэн чанар тодорхойлох
25.18		Сүүний нягт тодорхойлох
25.19		Сүү цагаан идээний чийг хуурай бодис тодорхойлох
25.20		Тослог тодорхойлох
25.21		Нийт уураг тодорхойлох
25.22	Хиам, Мах махан бүтээгдэхүүн	Чийг тодорхойлох
25.23		Үнслэг тодорхойлох
25.24		Чөлөөт тослог, өөх тосны хэмжээ тодорхойлох
25.25		Нитрит тодорхойлох
25.26		Азотын хэмжээ тодорхойлох
25.27		Шинэлэг байдал тодорхойлох
25.28		Ерөнхий эрдэс бодис тодорхойлох
25.29		Уургийн бодис тодорхойлох
25.30		Давсны хэмжээ тодорхойлох
25.31		Ундаа
25.32	Хуурай бодис тодорхойлох	
25.33	Чихэрлэгийн хэмжээ тодорхойлох	
25.34	Хүчиллэг тодорхойлох	
25.35	Тогтворжилт тодорхойлох	
25.36	Витамин С тодорхойлох	
25.37	Тунгалагшилт тодорхойлох	
25.38	Уураг тодорхойлох	
25.39	Талх чихэр, гурилан бүтээгдэхүүн	Чийг тодорхойлох
25.40		Хүчиллэг тодорхойлох
25.41		Сийрэгжилт тодорхойлох
25.42		Тослог тодорхойлох
25.43		Чихэрлэгийн хэмжээ тодорхойлох
25.44		Давсны хэмжээ тодорхойлох
25.45	Уураг тодорхойлох	
25.46	Хүнсний тос	Тунгалагшилт тодорхойлох
25.47		Хүчиллэг тодорхойлох
25.48		Давсны хэмжээ тодорхойлох
25.49		Ханаагүй хүчлийн хэмжээ тодорхойлох
25.50		Шинэлэг байдлын хэмжээ тодорхойлох
25.51	Элсэн чихэр	Цэвэршилт тодорхойлох
25.52		Чийг тодорхойлох
25.53		Сахарозын хэмжээ тодорхойлох
25.54		Хуурай бодисын хэмжээ тодорхойлох
25.55	Хүнсний ногоо	Эрдэс бодисын хэмжээ тодорхойлох
25.56		Нитрат тодорхойлох
25.57		РН тодорхойлох

25.58		С амин дэм тодорхойлох
25.59		Дээжний задаргаа хийх
25.60		Хар тугалга (Pb) тодорхойлох
25.61		Кадми (Cd) тодорхойлох
25.62		Хүнцэл (As) тодорхойлох
25.63		Төмөр (Fe) тодорхойлох
25.64	Атом шингээлтийн спектрометрийн шинжилгээ	Зэс (Cu) тодорхойлох
25.65		Хром (Cr) тодорхойлох
25.66		Цайр (Zn) тодорхойлох
25.67		Манган (Mn) тодорхойлох
25.68		Кобальт(Co) тодорхойлох
25.69		Никель (Ni) тодорхойлох
25.70		Мөнгөн ус тодорхойлох
26		Нэмэлт тусламж үйлчилгээ
26.1	Ажлын бус цагаар үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	
26.2	Эрүүл мэндийн байгууллага нь үндсэн үйл ажиллагаагаа алдагдуулахгүйгээр нөөц хүчин чадалд тулгуурлан үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэх тусламж үйлчилгээ	
26.3	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (энгийн)	
26.4	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (хагас люкс)	
26.5	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (люкс)	
26.6	Захиалгат хоол	
26.7	Захиалгат угаалга	
26.8	Захиалгат тээвэр	
27	Шарил хадгалах үйлчилгээ	
27.1	Шарил хадгалах үйлчилгээ /нэг хоногт, эмнэлгийн нас баралтаас бусад/	

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны...06... сарын 15... өдрийн
А/228 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үйлчлүүлэгчдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээ гэдэгт энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан тусламж, үйлчилгээ хамаарна.
- 1.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээг төв эмнэлэг болон тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, амаржих газар, сувилал, түргэн тусламжийн төвүүд үзүүлнэ.
- 1.4 Амаржих газар нь төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын зөвхөн 17, 26.3-26.5-т заасан тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.
- 1.5 Түргэн тусламжийн төв нь төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын зөвхөн 2-т заасан тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.
- 1.6 Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын зөвхөн 24, 25-т заасан тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.

Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөр төлөх

- 2.1 Эрүүл мэндийн даатгалгүй үйлчлүүлэгч Сангийн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан “Журам, төлбөрийн жишиг хэмжээ батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтад заасныг үндэслэн төлбөрийг бүрэн төлнө.
- 2.2 Эрүүл мэндийн даатгалд даатгуулсан үйлчлүүлэгч эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд Сангийн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан “Журам, төлбөрийн жишиг хэмжээ батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтад заасныг үндэслэн төлбөрийн зөрүүг төлнө.

2.3 “Эрүүл мэндийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан тусламж, үйлчилгээ буюу “Төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээ”-г авч буй иргэнээс төлбөр авахгүй. Эх хүүхэд, сэтгэцийн тусламж үйлчилгээнээс бусад төр хариуцдаггүй үлдэж буй тусламж үйлчилгээнээс төлбөр авна.

2.4 Үйлчлүүлэгч төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг зөвхөн төлбөр хураах төвлөрсөн цэгт төлж, төлбөр төлснийг нотлох баримт авна.

Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл

3.1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын вэб сайтад байрлуулна. Үүнд:

3.1.1 Сангийн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ /Хэрэв тухайн эрүүл мэндийн байгууллага өөрийн байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг жишиг хэмжээнээс доогуур баталсан бол тухайн төлбөрийн хэмжээ/

3.1.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний оношийн бүлгээрх жагсаалт, оношийн бүлэг тус бүрт даатгалын сангаас олгож буй санхүүжилтийн хэмжээ, даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ

Дөрөв. Бусад

4.1 Үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртлэх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр буцаан олгож, баримтжуулна.

4.2 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй.

Даатгуулагчийн хариуцан төлөх хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

- 4.3 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.
- 4.4 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчээс жагсаалтад зааснаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон бие засах газар, нөмрөг, улавч, машины зогсоол, хувцас өлгөх гэх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авахгүй.
- 4.5 Үйлчлүүлэгч эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.
- 4.6 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцно.